**ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2022 оны 10 сарын 05 өдөр — Дугаар А/207 — Улаанбаатар хот

## Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн $271^1$ дүгээр зүйлийн $271^1$.1.1, $271^1$.1.12 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол, Гаалийн ерөнхий газрын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Үйлчилгээ, аж ахуйн алба болон харьяа Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар, Орхон аймаг дахь гаалийн газрын балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалтыг хавсралт ёсоор батлсугай.

2. Хөрөнгийг хүлээлгэн өгөх, хүлээн авах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Үйлчилгээ, аж ахуйн алба /Ц.Отгонжаргал/-т, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар /Г.Батбаяр/-т, Орхон аймаг дахь гаалийн газар /Б.Майдармаа/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.АСРАЛТ

1439501 2886

Гаалийн ерөнхий газрын даргын
2022 оны 10 дугаар сарын 05-ны
өдрийн А/207 дугаар тушаалын хавсралт

**Гаалийн ерөнхий газрын дэргэдэх болон харьяа гаалийн газрын балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт**

/төгрөгөөр/

| № | Эзэмшиж буй газар, хороо | Бараа материал | Огноо | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг | Шилжүүлэх газар, хороод |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс | Процессор-энгийн үзүүлэлт | 9/30/2022 | 15 | 2,734,400.00 | 41,016,000.00 | - | 41,016,000.00 | Үйлчилгээ, аж ахуйн алба |
| | | Дэлгэц - энгийн үзүүлэлт | 9/30/2022 | 15 | 336,800.00 | 5,052,000.00 | - | 5,052,000.00 | |
| | | Принтер Hp laser pro 1 үйлдэлтэй, | 9/30/2022 | 1 | 979,000.00 | 979,000.00 | - | 979,000.00 | |
| | | **Дүн** | | **31** | | **47,047,000.00** | - | **47,047,000.00** | |
| | | Процессор-энгийн үзүүлэлт | 9/30/2022 | 2 | 2,734,400.00 | 5,468,800.00 | - | 5,468,800.00 | Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар |
| | | Дэлгэц - энгийн үзүүлэлт | 9/30/2022 | 2 | 336,800.00 | 673,600.00 | - | 673,600.00 | |
| | | **Дүн** | | **4** | | **6,142,400.00** | - | **6,142,400.00** | |
| | | Процессор-энгийн үзүүлэлт | 9/30/2022 | 1 | 2,734,400.00 | 2,734,400.00 | - | 2,734,400.00 | Орхон аймаг дахь гаалийн газар |
| | | Дэлгэц - энгийн үзүүлэлт | 9/30/2022 | 1 | 336,800.00 | 336,800.00 | - | 336,800.00 | |
| | | **Дүн** | | **2** | | **3,071,200.00** | - | **3,071,200.00** | |
| **НИЙТ** | | | | **37** | **0** | **56,260,600.00** | **0** | **56,260,600.00** | |